

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 20-НЫ
ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-4
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	5-13
	1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	5-13

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
12 дугаар сарын 20-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: М.Энхболд;

Тасалсан: О.Баасанхүү, Л.Оюун-Эрдэнэ, Д.Сумъяабазар, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, Ж.Эрдэнэбат.

Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, мөн хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Мэдээлэл, технологийн төвийн захирал Ж.Эрдэнэбат, Мэдээлэл, судалгаа арга зүйн хэлтсийн дарга Б.Оюумаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал С.Энхбаатар, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Нармандах, мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга, ахлах комиссар М.Даваатогтох, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Ч.Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Т.Батболд, Хуульч, өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх А.Солонго, референт Б.Золбоо, Л.Мөнхчимэг нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг Улсын Их Хурлын дарга өгсний дагуу санал хураалт явуулав.

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх
зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

С.Бямбацогт: 1.Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

28.10.Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглоно. Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан учир санал хураалтын дүнг дэмжсэнээр протоколд тэмдэглүүлэх санал гаргав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн саналыг оруулж тооцоод 11 гишүүн дэмжиж, 91.7 хувийн саналаар дэмжигдсэнд тооцов.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, С.Бямбацогт, Ж.Батзандан нар үг хэлэв.

2.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.6 дахь заалтын “аль нэг нам” гэснийг “намуудын олонх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.“Төслийн хууль хүчин төгөлдөр болох” гэсэн 85 дугаар зүйлд дагаж мөрдөх хугацааг “Энэ хуулийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

4.Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 33.2.10 дахь заалт нэмэх:

“33.2.10.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан үг хэлж, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга, ахлах комиссар М.Даваатогтох, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа нар тайлбар хийв.

5.Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 33.3.12 дахь заалт нэмэх:

“33.3.12.авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

С.Бямбацогт: 1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “8 дугаар” гэснийг “11 дүгээр” гэж, мөн зүйлийн “8.3.8” гэснийг “11.5.7” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг “Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:

С.Бямбацогт: 17.1.14-т “Сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгогчийг бүртгэх талаар мөн сонгуульд оролцож байгаа улс төрийн намууд нам, эвсэл сонгогчийн нэрсийн жагсаалтыг хувилж, олшруулж тараасан бол хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийн арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуралдаан 34 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
12 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР /БААСАН ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

С.Бямбацогт: Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдааны ирц хүрсэн тул 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 асуудалтай. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Эцсийн хэлэлцүүлэг. Монгол Улсын Их Хурлын даргаас сая чиглэл өгсөн. Тэр өгсөн чиглэлийн дагуу эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Та бүхэнд ажлын хэсгийг танилцуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Содномцэрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн захирал Эрдэнэбат, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Бат-Эрдэнэ, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Баасандорж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Нармандах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэргэжилтэн Дэлгэрмөрөн, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Энхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Зөрчил шалгах, мэргэжил, арга зүйн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Чинбат, Харилцаа, холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжлийн хэлтсийн дарга Лувсан-Очир, Харилцаа, холбооны зохицуулах хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Батболд, хууль, өмгөөлөгч Эрхэмбаатар, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга, ахлах комиссар Даваатогтох, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч Чинбат гэсэн ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна.

Сая чуулганы хуралдааны эцсийн хэлэлцүүлгийн үед зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явагдана. Өчигдөр чуулганы хуралдааны эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байхад Байнгын хороон дээр хэлэлцэж санал хураасан томъёоллоор биш, найруулсан томъёоллоор санал хураагдсан. Хураагдахаар уншигдсан. Үүнтэй холбоотойгоор бас үл ойлголцол үүсээд Байнгын хорооны дэмжигдсэн санал чуулганы хуралдаан дээр унасан учраас энэ асуудлыг бид бас эргэж ярих шаардлагатай байгаа.

Тэгэхээр зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд танилцуулъя. Та бүхэнд тараагдсан байгаа.

1.Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах: Энэ дээр манай зөвлөхүүд хаачсан бэ? Ердийн горимоор уу?

“28.10.Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” Асуулт Н.Энхболд гишүүн.

Н.Энхболд: Энэ Бямбацогт даргаа төсөлд анх орж ирэхдээ 28.10 чинь саяын агуулгаас гадна бас эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлж болохгүй, сонгуулийн зардлын данснаасаа бие даан зарлага гаргаж болохгүй, өөр намуудын эвсэлд нэгдэж орж болохгүй, бие дааж болоод өөр эвсэл байгуулж нөхөн, дахин сонгуульд оролцож болохгүй гээд ийм юмнууд бас байсан шүү дээ.

Тэрийг нь яагаад хассан юм бэ? Хэрэггүй гэж үзсэн юм уу, тэр эсхүл ингэж болно гэж үзэж байгаа юм уу? Энэ дээр тайлбар авахгүй бол энэ хориглосон зүйлүүдийг нь эргээд нээж байгаа юм шиг. Тэгэхээр энэ нөгөө эвсэл чинь утгагүй болчхоод. Эвсэл байгуулчхаад тэгээд байж байснаа дахин, нөхөн сонгууль болсон чинь нөгөө эвслийн нэг нам нь дангаараа нэр дэвшүүлээд яваад өгдөг. Эсхүл өөр намтай эвсээд, өөр эвсэл сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд байгуулаад явчихдаг гэх мэт ийм юм гарахгүй юу.

С.Бямбацогт: Хуулийн төсөл дээр байж байгаа 28.10 энэ байгаа заалт нь нэг талаасаа ингээд эвслийг маш хатуу тийм үү орсон л бол гарахгүй байхаар зохицуулалттай. Улс төрийн намууд эвссэн бол ерөөсөө гарч болохгүй юм шиг харагдаж байгаа. Нөгөө талаасаа эвссэн намуудаас нэг нам л гарчих юм бол эвсэл тарахаар ингээд нэг талаасаа харах юм бол хэт хатуу бүх намууд эвсээд орчих юм бол гарч болохгүй. Нөгөө талаасаа бол нэг л нам гарчих юм бол тарчихаар ийм байсан юм.

Тийм болохоор бид нар бас ярилцсан. Манай санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Болд гишүүн, Батзандан гишүүн нар ярилцаад эвслээс нэг л нам гарахад тэр эвсэл татан буугдахад нь улс төрийн намуудыг сонгуульд орох эрхийг нь хаах нь гэдэг үндэслэлээр ярьсан. Нөгөө талаасаа эвсэлд орсон нам гарах нь бас чөлөөтэй байх ёстой. Эвслээс гараад бас өөрсдөө сонгуульд оролцож тэр намууд оролцох бололцоо нээлттэй байх ёстой. Гэтэл гарах юм бол улс төрийн намууд бие даагаад өөрийнхөө намынхаа нэр дээр сонгуульдаа оролцох эрхийг нь хаачихаар энэ нь дахиад бас Үндсэн хууль зөрчинө гэдэг асуудал яригдсан учраас томъёоллыг харилцан ярилцаад, ойлголцоод эвсэлд орсон намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно гэдэг байдлаар томъёолох нь тэр эвсэлд орсон 10 намын 1 нь гарах юм бол тэр 9 намын эрх ашиг хохирохгүй байя.

Эвсэлд орсон намаас 6 нам нь үлдэх юм бол тэр эвсэл хэвээрээ байг. 4 нам нь өөрийнхөө нэрээр сонгуульд орох бололцоо нээлттэй байг гэдэг ийм бас уян хатан зохицуулалт болгож өөрчилье гэдэг томъёоллыг бас ярилцаад ажлын хэсэг дээр ярилцаад оруулж ирсэн юм гэдгийг хэлье.

Н.Энхболд: Тодруулъя.

С.Бямбацогт: Энхболд гишүүн микрофон өгье.

Н.Энхболд: Миний асуулт ойлгогдсонгүй бололтой. Би бол нэг л нам гарахад тардаг байхыг нь болиулаад олонх нь гарсан бол тавьдаг байх энэ заалтыг нь дэмжиж байгаа юм. Урд нь байгаа энэ заалтууд нь яах юм бэ? Жишээ нь 6 нам эвсэлд ороод явж байна тийм ээ. 2 нь гарчихлаа. 4 нь үлдээд эвслийнхээ үйл ажиллагаа үргэлжлүүлээд явж байна. Гэтэл тэр 4 дотроосоо дахиад дахин нөхөн сонгууль болохоор нөхөн сонгууль, дахин сонгууль болохоор тэр үлдсэн 4 дотроосоо нэг нь дангаараа нэр дэвшүүлээд, эсхүл зарлага гаргаад, өөр

намуудтай нэгдэж эвсэл болоод байх ийм зохицуулалтуудыг орхигдуулсан байна гэж байгаа юм.

Тэр нь уг нь хорьсон байгаа шүү дээ энд. Тэр нь байж байх нь илүүдэхгүй л юм шиг байгаа юм. Түүнээс би тэр олонх нь гарчихвал тардаг больё гэдэг зарчмыг нь бол дэмжиж байгаа ганц гэдгийг нь бол бас арай хатуу юм гэж. Наад энэ бусад одоо ... /минут дуусав/

С.Бямбацогт: Батзандан гишүүн санал гаргасан гишүүн тайлбарлах уу? Батзандан гишүүн.

Ж.Батзандан: Яагаад энэ эхний өгүүлбэрийг хассан юм бэ гэж ярьж байх шиг байна. Яг эхний өгүүлбэрийг унших юм бол эвслийн нэг нам нь дангаараа нэр дэвшүүлэх юм бол эвсэл чинь бас тарчхаж байгаа юм. Эвслийн нэг нам нь зардлынхаа данснаас бие даан зарлага гаргах л юм бол энэ чинь эвслийн бүрдэхгүй байх үндэслэл болчхоод байна гэж бид нар харж байгаа. Маш их эмзэг. Эвслийг эмзэг болгож байгаа заалтуудыг эхний өгүүлбэрт оруулсан байхгүй юу.

Өөр намуудыг эвсэлд нэгдэн орсон бол гэж байгаа юм. А эвслээс гараад Б эвсэл рүү нэг нам нь дангаараа оронгуут нөгөө анхны эвсэл чинь байхгүй болчхоод байгаа юм. Бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн болон дахин сонгуульд А эвсэлд байсан одоо 10 нам А эвслийг байгуулсан хэр нь 10 намаас 2 нам нь гараад нөхөн болон дахин сонгуульд оролцох юм бол эвсэл чинь өмнөх үндсэн эвсэл чинь тарчих гээд байгаа юм.

Тийм учраас хориглохыг энэ бол хориглоно гэдэг энэ заалт оруулаад оруулахаас гадна хэрэв эвслээс гараад эвслийн данснаас зарлага гаргасан тохиолдолд нь үндсэн эвслийг А эвслийг тарах үндэслэл болохгүй гэдэг агуулгаар оруулахын тулд бид ажилласан юм. Ажлын хэсэг дээр. Тэгээд ярьж, ярьж эцсийн түвшинд ер нь энэ эхний өгүүлбэрийг хасах нь зүйтэй юм байна. Зөвхөн эвсэлд нэгдсэн намуудын олонх нь л эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно гэдэг ийм тодорхой заалт оруулахгүй бол одоо Сонгуулийн ерөнхий хороон дээр очиход танай эвслийн нам чинь өөрийнхөө данснаас зарлага гаргасан байна гээд бүртгэж авахгүй байх магадлал үүснэ.

Танай эвсэлд байгаа нам чинь өөр эвсэл байгуулсан явж байна шүү дээ гэдэг асуудал үүснэ. Энэ нь бөөн маргаан дагуулна. Шүүх дээр очно гэдэг ийм асуудал яригдаад бид нар эхний өгүүлбэрийг нь хасах нь зүйтэй гэдэг томъёоллыг оруулж ирсэн юм.

С.Бямбацогт: Дахин Энхболд гишүүн.

Н.Энхболд: Үгүй ээ үгүй би зүгээр тэгвэл Батзандан гишүүний хариултаас ингэж л ойлголоо л доо. Одоо Улсын Их Хурлын сонгуульд 10 нам нэгдээд оръё тийм ээ. Сонгуульд эвсэлд болоод явж байлаа. Явц дундуур нь 4 нь гарчихлаа. Тэгвэл тэр эвслийг тарсан гэж үзэхгүй. 6 нь үргэлжлүүлээд явна тийм ээ. Их Хурлынхаа ажиллагаанд эвсэл нэрээрээ ороод явж байна. Гэтэл дундуур нь нөхөн, дахин сонгуулийн асуудал гарвал тэр 6 нам дотроос чинь аль нэг нь бие даагаад нэрээ дэвшүүлээд эсхүл өөр эвсэл байгуулаад явахыг зөвшөөрч байгаа юм байна шүү дээ тийм ээ. Тэгвэл энийгээ заалтаа нэг газар нь оруулаач дээ. Би үлдсэн 6 намынхаа асуудлыг л ярьж байна шүү дээ.

Үгүй ээ үгүй харин таны саяын хэлснээр бол нэгэнт одоо сонгогдсон. 10-аасаа 4 нь гарсан. 6 нь сонгогдоод эвсэл гээд явж байхад нөхөн, дахин сонгууль явбал тэр 6-аас чинь дахиад бие даагаад дэвшүүлж болно, бие даагаад өөр эвсэлд, бишээ биш. Нөхөн, дахин сонгуулийн тухай энд байгаа байхгүй юу. Дараагийн асуудлууд байна шүү дээ энд чинь. Түүнээс Их Хуралд орох эсэхийг ... /үг тасрав/

С.Бямбацогт: Саналаа хэллээ. Санал хураалт явуулъя. Санал хураалт 2/3-оор босно шүү гишүүдээ. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2018.10.Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Уншихгүй шүү дээ. Эхний хэсэг чинь ороод явахаар чинь юу яачхаад байгаа шүү дээ. Эхний хэсэг чинь орохоор ерөөсөө бусад намууд эвслээс гарах эрхийг нь хязгаарлаж байгаа байхгүй юу. Гарах юм бол сонгуульд оролцох эрхгүй болчхож байгаа юм. Батзандан гишүүн.

Ж.Батзандан: Тэгэхээр Нямаагийн Энхболд даргын санал, Нямдорж даргын санал, Лүндээжанцан гишүүний санал бол бас үндэслэлтэй сонсогдож байгаа юм. Эвслээс гарангуутаа дахин, нөхөн сонгуульд оролцоод явчих юм бол үнэхээр утгагүй болно. Тэгээд эвсэл чинь тараагүй байгаа шүү дээ. Үлдсэн 6 тэр эвсэл тараагүй л гэж үзнэ. Тэр 4 нам гарлаа гэж хэлснээр эвсэл тарахгүй. Эвсэл байдгаараа байна. Тэгэхээр тэр эвсэлд орсон намууд дахин, нөхөн сонгуульд оролцоно гэдэг ойлголт байхгүй. Бид хамтдаад бүрэн эрхийнхээ хугацаанд хамтдаа цаашаа явъя гэдэг. Ингээд манай ажлын хэсэг ажиллаад эхний өгүүлбэрийг нь 2 дахь өгүүлбэрээс нь салгаад эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эсвэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглоно.

Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно. Дээр нь бас ийм л ингээд ороход ер нь бараг болчих болов уу гэж би бодоод байна. Ажлын хэсэг референт зөвлөхүүд нэг.

С.Бямбацогт: Тэгэхээр энэ дээр чинь юу яачхаад байгаа юм л даа. Хамгийн гол нь эвслээс гарсан нам чинь тийм үү эвслээс нэг нам гарахад сонгуульд орох тэр эвсэлд орсон намууд бүгдээрээ сонгуульд орох эрх нь хаагдчихаад байна гээд бид нар олонх болгож байгаа шүү дээ. Тэгвэл олонх нь үлдээд бусад намууд нь гарах юм бол тэд нар чинь бас эвслээс гараад сонгуульд оролцох эрх нь хаагдчих гээд байгаа байхгүй юу. Хаагдана. Тэгэхээр тэр эвсэл чинь ерөөсөө хэдэн нам орчхоод л одоо хамтдаа тэгээд л яваад байх нь байна шүү дээ. Их Хурлын дарга Занданшатар дарга микрофон. Занданшатар гишүүний микрофон өгье.

Г.Занданшатар: Эвсэлд нэгдэнэ гэдэг чинь мөрийн хөтөлбөр, ард түмэнд амласан амлалтаараа нэгдэж байгаа шүү дээ тийм ээ. Тэгээд тэр нь хэсэг хүний санал зорилгоор хуураад дараа нь гарч, ороод ингээд байж болохгүй гэж илүү хариуцлагажуулж байгаа заалт. Нэгдсэн хариуцлага хүлээж орчхоод тэгээд салаад, энэ чинь цаад утгаараа ард түмнийг хуурч болохгүй гэсэн заалт байхгүй юу. Тийм.

Тэгэхээр энэ төслийн заалт өмнөх Сонгуулийн хуульд гэж байсан заалт гэж байсан заалт юм байна лээ. Тэгээд эхний хэсгээ оруулаад 2 заалтаа явахгүй бол болохгүй.

С.Бямбацогт: Би томъёоллыг одоо уншаад танилцуулъя тэгэх үү. Нэг заалтаар явъя. 1 заалтаар л уншъя.

28.10.Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглоно.

Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно. Болж байна уу? Батзандан гишүүн.

Ж.Батзандан: Нямдорж гишүүн, Баасанхүү гишүүн хоёр бас асуулт тайлбар нэхээд байгаа юм. Олонх нь гэж яг юу гэсэн үг юм бэ гэж. 2 намын эвсэл байгуулагдсан тохиолдолд олонх гэдэг бол 2 нам хоёулаа хамтарч нэгдсэн шийдвэр гаргаж байж эвсэл тарна гэсэн үг. Ингэж ойлгож байгаа. Манай Сонгуулийн ерөнхий хороо протоколд тэмдэглээд аваарай. 3 нам эвсэл байгуулсан тохиолдолд 2 нь гарсан тохиолдолд эвсэл тарж байна гэсэн үг. 4 нам эвсэл байгуулсан тохиолдолд 3 нь гарсан тохиолдолд. Тийм. Тэгээд олонх нь гэсэн үг. 5 байхад 3 тийм үү. Ингэж олонхоор явах юм. Эвслийг хариуцлагатай болгож өгч байгаа юм гэдэг ийм агуулгаар орж байгаа шүү.

Энэ дээр протоколд тэмдэглүүлээд энэ хуульдаа тайлбар хийх шаардлагатай юу Бямбацогт даргаа. Протоколд тэмдэглэгдэж байна. Ингэж ойлголоо шүү. 6 нам орсон тохиолдолд 4 нь гадаа эвслийг тараах гэдэг шийдвэр гаргасан бол эвсэл тарна гэсэн үг. Та бүхэнд баярлалаа ойлгосон явдалд.

С.Бямбацогт: Саяын одоо протоколд тэмдэглэлээ шүү дээ. 4 нам орсон тохиолдолд 2 нь гарах юм бол эвсэл тарна. Яг ийм томъёоллоор протоколд тэмдэглэгдлээ шүү. Саналын томъёоллыг сая уншсан тийм үү. “28.10.Эвслийн аль нэг нам дангаараа нэр дэвшүүлэх, намын сонгуулийн зардлын данснаас бие даан зарлага гаргах, өөр намуудын эвсэлд нэгдэн орох, бие даан болон өөр эвсэл байгуулан нөхөн, дахин сонгуульд оролцохыг хориглоно.

Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 2/3-ын саналтай байгаа шүү гишүүд анхааралтай байна уу. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Үнэхээр техникийн саатал гарсан байна. Жинхэнээсээ хурууны будилаан биш. Тогтохсүрэн гишүүнийг дэмжсэнд тооцъё. Тийм засаад өгчхөөрэй. Өөр юунд орохгүй бол болохгүй шүү дээ. Наашаа суучихгүй юу та. Дараагийн энэ санал дэмжигдсэн тохиолдолд бас хойд талд нэг санал хураах ёстой байж байгаа.

Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.6. одоо байгаа санал нь эвсэлд нэгдэн орсон нам аль нэг нам нь бүртгэсэн тухай шийдвэр гарахаас өмнө энэ хуульд заасны дагуу эвслээс гарахаа илэрхийлээгүй гэсэн заалт байсан бол үүнийг Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.6 дахь хэсгийн аль нэг нам гэснийг намуудын олонх гэж өөрчилье гэж байгаа юм. Нөгөө нэг нам гарна гэж байсан бол одоо үүнтэй уялдуулан намуудын олонх гэж өөрчлөх ийм байдлаар өөрчилье гэсэн

томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Төслийн хууль хүчин төгөлдөр болох гэсэн 85 дугаар зүйлд дагаж мөрдөх хугацааг энэ хуулийг 2019 оны ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Тогтохсүрэн гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Д.Тогтохсүрэн: 6 сарын 24 нь балжинням, дашнямтай юм биш шүү. Хууль хүчин төгөлдөр болох хугацааг 12 сарын 20, 19 оны 12 сарын 23 гэдэг, 23 гэдэг өдрөөс эхэлж тоолбол яасан юм бэ гэж бодож байна. Тийм. 1 сарын 01-нээс ингээд л энэ хууль чинь хэрэгжээд эхэлсэн л байх ёстой байхгүй юу. Тийм учраас би 12 сарын 23-ны өдрөөс дагаж мөрдөнө гээд тавивал яасан юм бэ гэдэг ийм горимын санал гаргаад байгаа юм. Горимын биш зарчмын зөрүүтэй санал.

С.Бямбацогт: Төслийн хууль хүчин төгөлдөр болох тийм үү Энэ хуулийг 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн зарчмын зөрүүтэй саналыг Тогтохсүрэн гишүүн гаргаж байна. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “8 дугаар” гэснийг “11 дүгээр” гэж, мөн зүйлийн “8.3.8” гэснийг “11.5.7” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 2 дугаар зүйлийг энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж өөрчлөх. Ийм 2 санал байгаа. Энэ нөгөө Засгийн газрын ээлжит бус сонгууль явуулахтай холбоотой Засгийн газрын тусгай сангаас гарах хөрөнгийн зохицуулалтыг тийм. Эхний санал хураалт.

1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “8 дугаар” гэснийг “11 дүгээр” гэж, мөн зүйлийн “8.3.8” гэснийг “11.5.7” гэж тус тус өөрчлөх. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. 11 гишүүнээс 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийг энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэж өөрчлөх, дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай бүхий 33.2.10 дахь заалт нэмэх: Энэ дээр сая нөгөө авлига албан тушаалын гэмт хэрэг шүүхээр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол дэвшүүлэхгүй гэсэнтэй холбогдуулаад энэ лавлагаа авах санал, лавлагаа авах ёстой болж байгаа юм. Бүртгүүлэхдээ нэр дэвшигч. Тэгээд тийм лавлагаа юу өгч байх зохицуулалт оруулахгүй бол болохгүй байгаа юм. Тэгээд энийг оруулъя.

“33.2.10.авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.” Энэ дээр одоо нөгөө ял шийтгүүлж байсан гэх юм уу шүүхээр гэх юм уу? Сая Аюурсайхан гишүүн. Батзандан гишүүн.

Ж.Батзандан: Шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ял шийтгүүлж байсан эсэх талаарх лавлагааг гаргуулж авах гэдэг ийм томьёоллоор оруулах нь зөв байх. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гэдэг бол 3 шатны шийдвэр нь гарсан байна гэсэн үг.

С.Бямбацогт: Тэгээд прокурор, цагдаагийнхан анхааралдаа авъя ажлын хэсэг. Хуульд бол сая авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглоно гэсэн томьёоллоор хуульд орж байгаа. Үүнтэй холбогдуулж энэ заалт орж ирж байгаа. Авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж байсан эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа гэдэг томьёолол оруулах гэж байна. Эсхүл яг хуульд орсон зүйл, заалттайгаа яг адилхан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон эсэх талаарх лавлагаа гэх юм уу? Аль нь зөв бэ? 1 дүгээр микрофон цагдаа. Чинбат, Авлигатай тэмцэх газар яах юм уу, Нямдаваа хариулах юм уу, хэн хариулах вэ? Аль томьёоллоороо зөв бэ? Та хэд бас хоорондоо ярилцаад байхгүй юу тийм ээ?

С.Бямбацогт: Хариулт юу болж байна вэ? Ярьж л байгаа юм уу. Хэн хариулах вэ? 1 дүгээр микрофон Чинбат прокурор хариулах уу?

М.Чинбат: Саяын асуултад хариулахдаа энэ цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн тэр хэлтсээс бол шүүхээр шийтгүүлсэн тодорхойлолт л гарч ирнэ л дээ. Тэр дотроо авлига албан тушаалын хэргээр байна уу, ямар хэргээр байна уу гэдэг тэр мэдээлэл нь доороо гараад ирэх юм. Түүнээс бол яг ийм хэргээр, тийм хэргээр гэдэг тэр нарийвчилж авах нэг их шаардлага байхгүй. Шүүхээр шийтгүүлсэн гээд яахаар шүүхээр шийтгүүлээд одоо бол ял шийтгэл оногдуулсан бол тодорхой гараад ирнэ. Ял шийтгэл шүүхээр шийдвэрлэгдээд гэм буруутайд тооцоод эрүүгийн хариуцлага оногдуулаагүй тийм бас тохиолдол гарч, гарч ирэхийг үгүйсгэхгүй л дээ.

Тэгэхээр тэр мэдээллээ юутай ч гэсэн Цагдаагийн ерөнхий газраас тодорхойлолт авч байж тэрэн дээр нь бас тэр эх хувиар нь авч байж л тэр нь харагдах ёстой болох байх. Тийм. Хууль дээр нь бас доод талд нь тайлбар хийх маягаар ч маягаар ч байдаг юм уу.

С.Бямбацогт: Зарчмын нэг их ялгаагүй л юм байна шүү дээ тийм үү?

М.Чинбат: Ялгаагүй л болох гээд байна.

С.Бямбацогт: Тэгвэл “33.2.10.авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.” Гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор. 2 дугаар микрофон. Санал хураалтад 11 гишүүн оролцож 9 гишүүний саяын санал дэмжигдлээ. 2 дугаар микрофон, Баасандорж бас ярих юм уу?

Л.Нямдаваа: Тодруулга хийе. Цагдаагийн ерөнхий газар Нямдаваа. Энэ нөгөө нэг саяын юу мэдээллийн лавлагаа тусдаа орж ирж байна гэж ойлголоо. 33.12 дээр. Тусдаа орж ирж байгаа бол 33.3.12, 33.2. хэд билээ? Бие даан нэр дэвшигч дээр бас нөгөө лавлагаа авах юмыг нь бас яг адилхан томьёоллоор оруулж ирэхгүй бол. 1 дээр орчхоод нөгөө дээр хаягдаж байгаа юм шиг харагдаад байна. Тийм. 33.2.10 дээр нэг оруулж ирээд, 33.3.12 дээр нэг тус тусад нь оруулж ирэхгүй бол нөгөө бие даан намаас нэр дэвшигч нар тус тусдаа нөгөө лавлагаагаа авна гэдэг адилхан орж ирнэ гэсэн үг.

С.Бямбацогт: 33.3.11.

Л.Нямдаваа: Одоо 11 дээр болохоор нөгөө нэг ял шийтгүүлж байсан гэдэг юу байгаа юм. Лавлагааг Цагдаагийн төв байгууллагын нэгжийн сангаас авна гээд. Бишээ одоо нэг өөрчилсөн шүү дээ. Энэ дээр 33.12 болгож дахиад яг нөгөө нэг авлигал албан тушаалын гэдэг саяын томьёолол чинь орж ирэх ёстой байх гэж бодож байна.

С.Бямбацогт: Тэгэхээр 33.2.10, 33.3.12 хоёрт саяын томьёоллыг нэмэх гэсэн агуулгаар уншигдах нь байна шүү дээ тийм үү. Энэ санал хураах хэрэгтэй юу? Тэгвэл сая 33.10-т заалтыг нэг хураасан. Одоо тэгвэл 33.3.12-т “33.3.12.авлига албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байсан эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын мэдээллийн сан хариуцсан нэгжийн лавлагаа.” Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Одоо Тогтохсүрэн гишүүн ажлын хэсгийн ахлагч.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. 1 горим, зарчмын зөрүүтэй нэг санал байна Бямбацогт даргаа. Зөрчлийн хуультай холбоотой. Сая Улсын Их Хурлын чуулган дээр эцсийн хэлэлцүүлэг дээр сонгогчдын нэрийн жагсаалтыг нөгөө цахим хэлбэрээр улс төрийн намуудад өгөхөөр хууль дэмжигдсэн заалт. Энэтэй холбогдуулаад түрүүн зарим гишүүд тухайлбал Нямдорж гишүүнээс эхлээд хэд хэдэн гишүүн хариуцлага нь юу юм бэ гэдэг асуудал яригдсан. Сая би энэ ажлын дэд хэсгийнхэнтэйгээ ярилцаж байгаад Зөрчлийн тухай хуулийн 14-г сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж, олшруулж тараасан бол хүнийг 5000 нэгтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 40000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж оруулъя гэж байгаа юм. Зөрчлийн тухай хуулийн 14 дээр. Тийм 14. Үгүй ээ яах вэ энэ ийм л юм байна. Тийм. Тэгвэл 50000 гээд орчихно. Бид нар нөгөө зарчим тийм байгаа. Тийм яах вэ интервалийг уу? Гэхдээ энийг заавал энд нь оруулах ёстой гэж байна. Их Хурлын хууль хэлэлцэж байгаа учраас энүүгээр нь оруулах ёстой. Тэгэхгүй бол орон нутгийн хууль хэлэлцэж байж энийг оруулж болохгүй гэж байна. Тийм учраас бол саяын 14 дүгээр зүйлийг сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилж, олшруулж тараасан бол хүнийг 5000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг 50000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэж оруулъя гэж байна.

Энэ угаасаа 15 дээр байгаа юм байна. 14 дээр тийм. 1000 нэгжтэй тэнцэх, тэгээд хуулийн этгээдийг 10000-тай гээд. Тэгэхээр энэ дээр нөхцөлөө хэлээд өгчих та. Сонгогчдын нэрсийн жагсаалтыг хувилж тараасан бол гэдгээр ойлгож болох уу? Санкц нь бол байна. Хувилж, олшруулж тараасан бол гэсэн нөхцөлтэйгөөр оруулъя. Санал хураах хэрэгтэй юу? Санкц нь байж байгаа. Тэгвэл саяын томьёоллоор санал хурааа. Алив гараад ир дээ. Зөрчлийн хуулийн 14-т сонгогч мөн үү? 17.1 дүгээр зүйлийн 14-т сонгогчдын нэрсийн жагсаалтыг үйлдэх,

танилцуулах, хүргүүлэх, сонгогчдыг бүртгэх талаарх гэдэг дээр нэмээд сонгогчдын нэрсийн жагсаалтыг хувилж, олшруулж тараасан бол. 14 дээр орж байгаа шүү дээ. Баасандорж 2 дугаар микрофон.

Б.Баасандорж: Тогтохсүрэн гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбоотой сая 14 дэх саналыг бол яах аргагүй өөрчлөн найруулахгүй бол Тогтохсүрэн гишүүний хэлснийг өөрчлөн найруулахгүй бол энэ Зөрчлийн хуулийн концепцтой зөрчилдөх гээд байгаа юм. Яг энэ 14-ийг уншихаар төрийн албан хаагчид руу, үйлдэх бол энэ бүртгэгчийн хийх ажил, танилцуулах бүртгэгчийн хийх ажил, хүргүүлэх бүртгэгчийн хийх ажил. Тэгэхээр одоо энийг яг саяын Тогтохсүрэн даргын хэлснээр гэхдээ 1 өгүүлбэр нэмэх гэж бол хэрэв гишүүд зөвшөөрвөл.

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн улс төрийн нам, эвсэл сонгогчийн нэрийн жагсаалтыг хувилж олшруулж тараасан бол тэдэн төгрөгөөр гэсэн санкц хийх ёстой.

С.Бямбацогт: Тэгвэл 14 дээр орох юм байна тийм үү. 17.1.14-т сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх, сонгогчийн бүртгэх талаар мөн сонгуульд оролцож байгаа улс төрийн намууд нам эвсэл сонгогчийн нэрсийн жагсаалтыг хувилж, олшруулж тараасан бол хүнийг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийн арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Энэ урд талын юунд нь нөхцөлд нь бас хүн байгаа юм. Тийм. Энэ томьёоллоор санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор. Санал хураалтад 11 гишүүн оролцож 8 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууслаа. Хуралдаа оролцсон гишүүддээ баярлалаа. Хуралдаан хаасныг мэдэгдье.

Дууны бичлэгээс буулгасан:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

